

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВД БАЙРЛАЖ БУЙ ИРГЭДИЙН 2025 ОНЫ IV ДУГААР УЛИРЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН ДҮГНЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 15  
хот

Улаанбаатар


**Зорилго:** нийгмийн хамгааллын тусгай төвийн үйлчилгээний чанар хүртээмж болон албан хаагчдын харилцаа хандлагыг үнэлэх.

**Хамрах хүрээ:** нийгмийн хамгааллын тусгай төвөөс түр хоноглох байрны үйлчилгээ авч буй иргэд.

**Асуулгын бүтэц:** сэтгэл ханамжийн судалгаа нь нийт 6 үзүүлэлт 22 асуулттай. үүний 21 нь хагас нээлттэй асуулт, 1 нь нээлттэй асуулт байв.


**Судалгаанд оролцогч:** судалгаанд нийт 34-70 насны 40 иргэн хамрагдсан бөгөөд үүний 8 нь эмэгтэй, 32 нь эрэгтэй оролцогч

1.Нийгмийн хамгааллын тусгай төвөөр хэр удаан үйлчлүүлж байна вэ? гэсэн асуултын хариултыг график 1-т харууллаа. График 1



Судалгаанд оролцсон иргэдийн 15% нь нийгмийн хамгааллын тусгай төвөөс 1-4 долоо хоног хүртэлх хугацаагаар үйлчилгээ авч байгаа бол 20% нь 1-3 сар, 18% нь 3-6 сар хүртэлх хугацаагаар үйлчилгээ авсан ба 20% нь 6-12 сар 17% нь 1-2 жил үйлчилгээ авч буй харин үлдсэн 8% нь 2 жилээс дээш хугацаагаар нийгмийн хамгааллын тусгай төвөөр үйлчлүүлж байна.


2. Төвийн ая тухтай байдлыг үнэлэхэд чиглэсэн 1.1, 1.2, 1.3, 1.4, асуултад өгсөн хариултын үр дүнг график 2-т харуулав. График-2



Төвийн ариун цэврийн өрөө, шүршүүр цэвэр эсэх дээр иргэдийн 58% нь маш сайн, 15% нь сайн, 12% нь дунд, гэж үнэлсэн бол үлдсэн 15% нь маш муу хэмээн

үнэлсэн. Харин амрах газар буюу суудал, буйдан, ор хангалттай хүрэлцээтэй эсэх дээр 55% нь маш сайн, 20% нь сайн, 8% дунд гэж үнэлсэн бол 2% нь муу, үлдсэн 15% нь маш муу хэмээн үнэлсэн. Өрөө гэрийн ор, хөнжил цэвэр тухтай байдал дээр 50% маш сайн, 33% нь сайн гэсэн үнэлгээ өгсөн бол 2% муу харин үлдсэн 15% нь маш муу гэсэн хариултыг өгсөн. Өрөө гэрийн дулаан, агааржуулалтыг 50% маш сайн, 33% нь сайн, 5% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн бол 5% нь муу, үлдсэн 15% нь маш муу гэсэн хариултыг өгсөн.

3. Хооллох орчин нөхцөл, хүртээмжийг үнэлэхэд чиглэсэн 2.1, 2.2, 2.4 асуултад өгсөн хариултын үр дүнг график 3-т харуулав. График3



Хооллох орчин нөхцөл тав тухтай гэсэн асуултад 58% нь маш сайн, 15% нь сайн, 12% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн бол үлдсэн 15% нь маш муу хэмээн үнэлсэн. Хоолны төрөл /мах ногоо талх гэх мэт/ хангалттай гэсэн асуултад 48% нь маш сайн, 22% нь сайн, 13% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн бол 2% нь муу хэвээн үнэлсэн бол үлдсэн 15% нь маш муу хэмээн үнэлсэн. Хоолны амт чанар, хүртээмж 45% нь маш сайн 30% нь сайн гэж үнэлсэн бол 8% дунд үлдсэн 17% нь маш муу гэсэн хариултын өгсөн.

4. Төвийн албан хаагчдын харилцаа хандлагыг үнэлэхэд чиглэсэн 1.5, 1.6, 1.7, 3.1, 4.1, 5.1 асуултад өгсөн хариултын үр дүнг график 4,5-т харуулав.

График-4





График-5




Судалгаанд оролцогчдын 50% нь нийгмийн ажилтнуудын харилцаа хандлага маш сайн гэж үнэлсэн бол 25% нь сайн үлдсэн 10% нь маш муу гэж үнэлсэн. Харин сэтгэл зүйчийн харилцаа хандлагыг 70% нь маш сайн, гэж үнэлсэн бол 20% нь сайн үлдсэн 10% нь маш муу гэж үнэлсэн.

Эмчийн харилцаа хандлагыг 58% нь маш сайн, 17% нь сайн гэж үнэлсэн бол 15% нь дунд үлдсэн 10% нь маш муу гэж үнэлсэн. Харин байрны багшийн харилцаа хандлагыг 55% нь маш сайн, 25% нь сайн гэж үнэлсэн бол 5% нь муу үлдсэн 15% нь маш муу гэж үнэлсэн. Жижүүрийн харилцаа хандлагыг 50% нь маш сайн, 35% нь сайн гэж үнэлсэн бол үлдсэн 15% нь маш муу хэмээн үнэлсэн. Тогоочийн харилцаа хандлагыг 55% нь маш сайн, 25% нь сайн гэж үнэлсэн бол 5% нь муу үлдсэн 15% нь маш муу хэмээн үнэлсэн. Үйлчлэгчийн харилцаа хандлагыг 50% нь маш сайн, 35% нь сайн хэмээн үнэлсэн бол үлдсэн 15% нь маш муу хэмээн үнэлсэн. Оффисын ажилчдын харилцаа хандлагыг 63% нь маш сайн, 22% нь сайн хэмээн үнэлсэн бол 5% нь дунд үлдсэн 10% нь маш муу хэмээн үнэлсэн байна.

5. Иргэдийн үйлчилгээ авч буй орчин нөхцөлийг хандлагыг үнэлэхэд чиглэсэн 3.3, 4.3, 5.3 асуултад өгсөн хариултын үр дүнг график 4,5-т харуулав.

График-6



Нийгмийн ажлын үйлчилгээ авч буй орчин нөхцөлийг 63% нь маш сайн, 25% нь сайн хэмээн үнэлсэн бол 2% нь дунд үлдсэн 10% нь маш муу хэмээн үнэлсэн. Сэтгэл зүйн үйлчилгээ авч буй орчин нөхцөлийг 63% нь маш сайн, 20% сайн хэмээн үнэлсэн бол 7% нь дунд үлдсэн 10% нь маш муу хэмээн үнэлсэн. Эрүүл мэндийн үйлчилгээ авч буй орчин нөхцөлийг 53% нь маш сайн, 15% нь сайн хэмээн үнэлсэн бол 22% нь дунд үлдсэн 10% нь маш муу хэмээн үнэлсэн байна.

6. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч нарын үйлчилгээний чанар хүртээмжийг хандлагыг үнэлэхэд чиглэсэн 3.2, 4.2, 5.2 асуултад өгсөн хариултын үр дүнг график 4,5-т харуулав.

График-7



Нийгмийн ажилтнуудын үйлчилгээний хүртээмж чанарт 65% нь маш сайн, 25% нь сайн хэмээн үнэлсэн бол 10% нь маш муу хэмээн үнэлсэн. Сэтгэл зүйн үйлчилгээний хүртээмж чанарт 65% нь маш сайн, 23% нь сайн хэмээн үнэлсэн бол 2% нь дунд үлдсэн 10% нь маш муу хэмээн үнэлсэн. Эмнэлгийн үйлчилгээний хүртээмж чанарт 50% нь маш сайн, 18% нь сайн хэмээн үнэлсэн бол 20% нь дунд үлдсэн 12% нь маш муу хэмээн үнэлсэн.

7. Тус төвийн үйл ажиллагааг та цаашдаа ямар байгаасай гэж хүсэж байна вэ? Гэсэн нээлттэй асуултын хариултыг хүснэгтэд харуулав.

*Жич: Судалгаанд судлаачийн зүгээс субъектив нөлөөлөл оруулахгүйн тулд үйлчлүүлэгч иргэдээс ирсэн санал хүсэлт, шүүмж, талархлын үг өгүүлбэрийг засваргүйгээр оруулсан болно.*

## Хүснэгт 1

	<b>Санал, хүсэлт</b>	<b>Шүүмж</b>	<b>Талархал</b>
1	Олон хүнд тус болж, зөв ёс суртахуун, хүмүүжилтэй болгож өгөөрэй	Байрны дотоод цэвэрлэгээ болон 00-ыг сайн цэвэрлэж байх 1	Олон хүнийг зөв амьдралд хөтлөн оруулж байгаад маш их баярлаж байна.
2	Төвийн үйл ажиллагаа улам хүндээ хүрсэн хүртээмжтэй нийгэмшихэд туслаасай хэмээн хүсэж байна-1		Одоогийн үйл ажиллагаа таалагдаж байна. Илүү сайн хичээгээрэй- 10
3	Цаашид иргэдтэйгээ тулж ажиллах, харилцах үйлчилгээгээ сайжруулах 1		
4	Үйлчлүүлэгч нартайгаа илүү ойр ярилцаж, тулж харилцаасай-1		
	<b>Санал, хүсэлт- 4</b>	<b>1</b>	<b>Талархал- 11</b>

## Дүгнэлт

Нийгмийн хамгааллын тусгай төвөөс үйлчилгээ авч буй иргэдийн 2025 оны IV улирлын сэтгэл ханамжийн судалгаанд 34–70 насны нийт 40 иргэн хамрагдсаны 80 хувь нь эрэгтэй, 20 хувь нь эмэгтэй байв. Судалгаанд оролцогчид нь төвөөс 1 сараас 2 жил хүртэл хугацаанд үйлчилгээ авч байгаа иргэд байна. Албан хаагчдын харилцаа, хандлагын үнэлгээг нэгтгэн дүгнэхэд оролцогчдын 83 хувь нь “маш сайн”, “сайн”, харин 17 хувь нь дундаас доогуур үнэлсэн байна.

Үйлчилгээний хүртээмж, чанарыг 82% хувь нь “маш сайн”, “сайн” гэсэн бол 18% нь дундаас доогуур үнэлсэн байна. Нийгмийн ажил, сэтгэл зүй, эрүүл мэндийн үйлчилгээ авч буй орчин нөхцөлийн үнэлгээг нэгтгэн дүгнэхэд оролцогчдын 80% нь маш сайн, сайн, харин 20% нь дундаас доогуур үнэлсэн байна.

Хооллох орчин нөхцөл, хоолны төрөл, амт чанар, хүртээмжийн үнэлгээг нэгтгэн дүгнэхэд оролцогчдын 73 хувь нь маш сайн, сайн, харин 27 хувь нь дундаас доогуур гэж үнэлсэн байна. Төвийн ая тухтай байдал, ариун цэврийн өрөө, амрах байр, ор хөнжлийн цэвэр тухтай байдал, өрөөний дулаан, агааржуулалтын үнэлгээг нэгтгэн дүгнэхэд оролцогчдын 79% нь “маш сайн”, “сайн”, харин 23% нь дундаас доогуур үнэлсэн байна. Мөн санал хүсэлт гэсэн нээлттэй асуултад 1 шүүмж, 4 санал, 11 талархал ирсэн байна.

Дээрхээс дүгнэхэд ажилтан албан хаагчдын харилцаа хандлага, үйлчилгээний чанар хүртээмж, үйчүүлэгчийн орчин нөхцөл зэрэгт онцгой анхаарал хандуулж сайжруулах ажлыг үр дүнтэйгээр үе шаттай хамтран зохион байгуулах нь зүйтэй хэмээн дүгнэж байна.

ХЯНАСАН  
НИЙГЭМ СЭТГЭЛ ЗҮЙН АЛБАНЫ ДАРГА

Б.БАЛЦЭЦЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН:  
СЭТГЭЛ ЗҮЙЧ

Б.СОЛОНГО